



ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Ж.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 89

танай _____-ны № _____-т

**2023 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн 2,263.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 1,092.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/10/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Орхон аймаг 2024 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Гантуяа Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УТ	Улсын төсөв
ОНТ	Орон нутгийн төсөв



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 58

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Ж.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 54.9 хувиар өсөж, төсвийн хуваарийг 1 удаа өөрчлөн баталсан байна.

Засаг даргын захирамжаар нийт 265,800.1 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс олгож буй 40 хувийн нэмэгдэл цалин 58,533.4 мянган төгрөг, ЖДҮХС-ийн зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхээр 898.6 мянган төгрөг нийт 325,232.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Бараа материалын дансны үлдэгдэл 3,272,881.8 мянган төгрөг болж 1,844,077.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон талт түншлэлийн хүрээнд “Үйлдвэрлэгч баг” төслийн багц 2-ын үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл 1,470,000.0 мянган төгрөг, “Шинэ хөдөө” төслийн багийн үйлдвэрийн тоног төхөөрөмж 546,956.7 мянган төгрөгийн

тоног төхөөрөмжүүдийг бараа материалын тайланд бүртгэж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдэд гэрээгээр олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 18 зорилт, 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг 96.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,429,698,232.96</u>	<u>3,286,053,391.66</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	894,300.00	984,800.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	894,300.00	984,800.00
3121	Төгрөг	894,300.00	984,800.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	894,300.00	984,800.00
33	АВЛАГА	-	12,186,802.40
335	Бусад авлага	-	12,186,802.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	12,186,802.40
35	БАРАА МАТЕРИАЛ	1,428,803,932.96	3,272,881,789.26
351	Түүхий эд материал	1,186,613,103.54	3,133,302,871.24
35110	Тусгай зориулалттай материал	1,186,613,103.54	3,133,302,871.24
35300	Бэлэн бүтээгдэхүүн	99,198,695.40	47,996,914.00
354	Хангамжийн материал	142,992,134.02	91,582,004.02
35410	Бичиг хэргийн материал	342,650.00	3,274,900.00
35420	Аж ахуйн материал	3,773,800.00	5,267,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,550,000.00	570,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	5,452,500.00
35460	Хүнсний материал	-	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	136,325,684.02	76,517,404.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>330,172,315.67</u>	<u>453,666,630.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	330,172,315.67	453,666,630.12
392	Биет хөрөнгө	324,385,315.75	448,529,630.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	61,364,496.87	61,364,496.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,980,536.64)	(21,705,331.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,748,772.52	184,148,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(109,637,661.23)	(112,748,772.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	206,410,097.23	207,050,097.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,536,389.23)	(79,833,374.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,100,963.16	243,602,963.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,084,426.93)	(33,349,220.53)
393	Биет бус хөрөнгө	5,786,999.92	5,136,999.88
39301	Програм хангамж	4,300,000.00	4,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,375,000.08)	(4,025,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,862,000.00	4,862,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,759,870,548.63</u>	<u>3,739,720,021.78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,759,870,548.63</u>	<u>3,739,720,021.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,759,870,548.63	3,739,720,021.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	292,689,889.75	292,689,889.75
51101	Өмч: - төрийн	292,689,889.75	292,689,889.75
512	Хуримтлагдсан үр дүн	1,461,856,267.78	3,441,705,740.93
51210	Өмнөх үеийн үр дүн	(66,696,775.95)	1,461,856,267.78
51220	Тайлант үеийн үр дүн	1,528,553,043.73	1,979,849,473.15

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,324,391.10	5,324,391.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,759,870,548.63	3,739,720,021.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,476,195,289.50	3,273,033,576.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,674,837,581.50	2,299,755,045.45
120	Нийтлэг татварын бус орлого	1,674,837,581.50	2,299,755,045.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,674,837,581.50	2,299,755,045.45
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,674,837,581.50	2,299,755,045.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	801,357,708.00	973,278,531.25
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	299,523,300.00	648,046,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	299,523,300.00	648,046,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	501,834,408.00	325,232,131.25
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	498,334,400.00	325,232,131.25
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	916,251,277.77	1,244,437,023.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,251,277.77	1,244,437,023.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,889,883.13	1,194,230,276.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,171,579.47	474,606,262.27
210101	Үндсэн цалин	162,160,330.45	295,095,671.44
210102	Нэмэгдэл	33,396,838.07	129,893,543.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,020,400.00	28,994,886.74
210104	Урамшуулал	8,594,010.95	20,622,160.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,154,794.47	58,885,792.97
210201	Тэтгэврийн даатгал	18,610,850.51	40,275,197.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,189,511.80	4,738,258.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,744,889.42	3,781,806.84
210204	Ажилгүйдлийн даатгал	419,049.22	917,320.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,190,493.52	9,173,208.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,526,519.98	38,277,270.28
210301	Гэрэл, цахилгаан	579,076.31	1,519,969.00
210302	Түлш, халаалт	1,991,726.55	4,193,996.94
210303	Цэвэр, бохир ус	1,128,501.12	2,894,936.34
210304	Байрны түрээс	24,827,216.00	29,668,368.00
2104	Хангамж, бараа материалын зардал	134,980,577.44	132,075,055.75
210401	Бичиг хэрэг	5,082,270.00	8,278,900.00
210402	Тээвэр, шатахуун	32,385,300.00	30,714,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,126,347.44	1,180,120.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	2,750,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	96,120,660.00	62,596,170.00
210408	Бараа материал акталсны зардал	-	26,309,615.75
2105	Нормативт зардал	9,226,500.00	45,712,100.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	745,000.00	160,000.00
210502	Хоол, хүнс	8,481,500.00	45,552,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,960,000.00	4,895,000.00
210604	Урсгал засвар	1,960,000.00	4,895,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,795,800.00	6,075,600.00
210702	Дотоод албан томилолт	8,795,800.00	6,075,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	331,982,614.00	95,379,628.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,675,000.00	90,255,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	417,470.00	263,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,940,000.00	4,740,000.00
210807	Газрын төлбөр	131,184.00	76,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,091,497.77	338,323,566.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,762,152.44	267,275,881.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,329,345.33	71,047,685.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,361,394.64	50,206,747.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,360,000.00	33,500,864.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,371,364.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,360,000.00	12,129,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,001,394.64	16,705,883.73
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	(800,000.00)
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,001,394.64	17,505,883.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,559,944,011.73	2,028,596,552.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,390,968.00	48,747,079.60
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	31,390,968.00	48,747,079.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,390,968.00)	(48,747,079.60)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,528,553,043.73	1,979,849,473.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	809,205,450.00	973,278,531.25
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	810,065,450.00	972,548,031.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	810,065,450.00	972,548,031.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,704,055.36	922,341,283.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,171,579.47	474,606,262.27
210101	Үндсэн цалин	162,160,330.45	295,095,671.44
210102	Нэмэгдэл	33,396,838.07	129,893,543.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,020,400.00	28,994,886.74
210104	Урамшуулал	8,594,010.95	20,622,160.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,154,794.47	58,885,792.97
210201	Тэтгэврийн даатгал	18,610,850.51	40,275,197.75

210202	Тэтгэмжийн даатгал	2,189,511.80	4,738,258.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,744,889.42	3,781,806.84
210204	Ажилгүйдлийн даатгал	419,049.22	917,320.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,190,493.52	9,173,208.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,676,519.98	38,277,270.28
210301	Гэрэл, цахилгаан	729,076.31	1,519,969.00
210302	Түлш, халаалт	1,991,726.55	4,193,996.94
210303	Цэвэр, бохир ус	1,128,501.12	2,894,936.34
210304	Байрны түрээс	24,827,216.00	29,668,368.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,431,647.44	62,105,220.00
210401	Бичиг хэрэг	3,988,200.00	7,704,650.00
210402	Тээвэр, шатахуун	29,912,100.00	35,036,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,126,347.44	1,208,120.00
210404	Ном, хэвлэл	12,508,000.00	16,813,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,371,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,526,000.00	1,096,700.00
2105	Нормативт зардал	23,613,600.00	40,928,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	745,000.00	-
210502	Хоол, хүнс	18,258,600.00	40,478,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,610,000.00	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,372,800.00	24,792,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,952,500.00	1,437,300.00
210604	Урсгал засвар	5,420,300.00	23,355,570.00
2107	Томилолт, зочны зардал	8,795,800.00	6,075,600.00
210702	Дотоод албан томилолт	8,795,800.00	6,075,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,133,614.00	135,204,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	343,226,000.00	130,081,240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	201,960.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	417,470.00	263,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	4,740,000.00
210807	Газрын төлбөр	131,184.00	76,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,353,700.00	81,465,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,353,700.00	81,465,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,361,394.64	50,206,747.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,360,000.00	33,500,864.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,371,364.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,360,000.00	12,129,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,001,394.64	16,705,883.73
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	(800,000.00)
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,001,394.64	17,505,883.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(860,000.00)	730,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	640,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	640,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	640,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	640,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(640,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(860,000.00)	90,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,754,300.00	894,300.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	894,300.00	984,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	-66,696,775.95	0.00	231,317,504.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	-66,696,775.95	0.00	231,317,504.90
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,528,553,043.73	0.00	1,528,553,043.73
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	1,461,856,267.78	0.00	1,759,870,548.63
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	1,461,856,267.78	0.00	1,759,870,548.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	1,461,856,267.78	0.00	1,759,870,548.63
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,979,849,473.15	0.00	1,979,849,473.15
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,689,889.75	5,324,391.10	3,441,705,740.93	0.00	3,739,720,021.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	648,846,400.00	631,455,968.22	4,725,900.00	99.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,846,400.00	631,455,968.22	4,725,900.00	99.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625,203,000.00	607,764,604.22	4,725,900.00	99.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,185,800.00	422,605,099.67	2,580,700.33	
210101	Үндсэн цалин	258,640,200.00	258,661,521.04	(21,321.04)	100.01
210102	Нэмэгдэл	112,996,900.00	114,326,531.09	(1,329,631.09)	101.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,152,700.00	28,994,886.74	1,157,813.26	96.16
210104	Урамшуулал	23,396,000.00	20,622,160.80	2,773,839.20	88.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,149,400.00	52,410,476.27	738,923.73	98.61
210201	Тэтгэврийн даатгал	36,141,200.00	35,855,098.97	286,101.03	99.21
210202	Тэтгэмжийн даатгал	4,252,000.00	4,218,246.98	33,753.02	99.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,401,700.00	3,365,797.54	35,902.46	98.94
210204	Ажилгүйдлийн даатгал	850,700.00	815,575.75	35,124.25	95.87

210205	Эрүүл мэндийн даатгал	8,503,800.00	8,155,757.03	348,042.97	95.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,478,300.00	37,827,270.28	651,029.72	98.31
210301	Гэрэл, цахилгаан	1,686,500.00	1,519,969.00	166,531.00	90.13
210302	Түлш, халаалт	4,475,100.00	4,193,996.94	281,103.06	93.72
210303	Цэвэр, бохир ус	3,098,300.00	2,894,936.34	203,363.66	93.44
210304	Байрны түрээс	29,218,400.00	29,218,368.00	32.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,164,100.00	11,783,720.00	2,380,380.00	83.19
210401	Бичиг хэрэг	7,255,800.00	4,826,700.00	2,429,100.00	66.52
210402	Тээвэр, шатахуун	4,406,200.00	4,406,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,000.00	1,208,120.00	(68,120.00)	105.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	246,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,116,100.00	1,096,700.00	19,400.00	98.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,433,400.00	25,432,870.00	530.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,077,800.00	2,077,300.00	500.00	99.98
210604	Урсгал засвар	23,355,600.00	23,355,570.00	30.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,306,500.00	3,328,000.00	1,978,500.00	62.72
210702	Дотоод албан томилолт	5,306,500.00	3,328,000.00	1,978,500.00	62.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,840,300.00	52,937,868.00	7,902,432.00	87.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,604,500.00	47,814,140.00	6,790,360.00	87.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	355,800.00	-	355,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	132,700.00	-	132,700.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,700.00	263,700.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	44,000.00	33,000.00	57.14
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,004,700.00	4,740,000.00	264,700.00	94.71
210807	Газрын төлбөр	401,900.00	76,028.00	325,872.00	18.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,645,200.00	1,439,300.00	1,205,900.00	54.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,645,200.00	1,439,300.00	1,205,900.00	54.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,643,400.00	23,691,364.00	(47,964.00)	100.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,643,400.00	23,691,364.00	(47,964.00)	100.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,371,400.00	21,371,364.00	36.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,272,000.00	2,320,000.00	(48,000.00)	102.11
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		17,390,431.78	17,390,431.78	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	653,572,300.00	648,846,400.00	4,725,900.00	99.28
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	653,572,300.00	648,846,400.00	4,725,900.00	99.28
122005	Улсын төсвөөс	653,572,300.00	648,846,400.00	4,725,900.00	99.28

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эрхлэх асуудлын зорилт чиг үүргийн хэрэгжилтийг хангахад хүнс, хөдөө аж ахуйн талаарх бодлогыг дэмжих, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд харьяалалтай, яамнаас бодлого арга зүйгээр хангагдаж, салбарын бодлого шийдвэрийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэн ажилладаг байгууллага юм.

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, үйлдвэрийн орлого бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тус газар нь 2023 онд 18 зорилт, 78 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг 96.5 хувьтай гүйцэтгэсэн байна. Зорилт арга хэмжээний хүрээнд Засгийн газрын бодлого шийдвэрийн 26 арга хэмжээ, салбарын бодлого шийдвэрийн 7 зорилт 8 арга хэмжээ, аймгийн бодлого, зорилтын 45 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь хүнсний үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, бүтээгдэхүүний хангамж аюулгүй байдлыг сайжруулах, мал сүргийн чанарыг сайжруулж, байгалийн эрсдэлээс сэргийлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, газар тариаланд дэвшилттэй техник технологи нэвтрүүлж, га-ын ургацын хэмжээг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хоршооны салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллага нь тайланд онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль
- Малын генетикийн нөөцийн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол улсын Их хурлын тогтоол 2022 оны 36 дугаар тогтоол

- Монгол улсын Их хурлын тогтоол 2022 оны 19 дугаар тогтоол
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 6, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2, Хөдөлмөрийн тухай хуульд 3, Төрийн албаны тухай хуульд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ"-г шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 308 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ыг 2023 оны 08 дугаар сарын 23-нд баталж, мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл болон шилэн данс, төрийн хэмнэлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тоо байдаг ч гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг аудитад ашиглах шаардлага үүсээгүй болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний А/885 дугаар тушаалын хавсралтаар баталсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,979.849.5 мянган төгрөгөөр буюу 112 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	894.3	984.8	90.5
Авлага		12,186.8	12,186.8
Бараа материал	1,428,803.9	3,272,881.8	1,844,077.9
Үндсэн хөрөнгө	330,172.3	453,666.6	123,494.3
Нийт хөрөнгө	1,759,870.5	3,739,720.0	1,979,849.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,759,870.5	3,739,720.0	1,979,849.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,759,870.5	3,739,720.0	1,979,849.5

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 1,979.849.5 мянган төгрөгөөр өсөхөд бараа материалын данс нөлөөлжээ.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 90.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын дансны 12,186.8 мянган төгрөгийн үлдэгдэл нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 60,900.0 мянган төгрөгийн хүнсний ногооны үр авч, Баян-Өндөр болон Жаргалант суманд хуваарилж, 80%-ийн хөнгөлөлттэй үнээр иргэдэд олгож, 20%-ийн үнийг хүмүүсээс авах авлагаар тайланд тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,272,881.8 мянган төгрөг болж 1,844,077.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төслийн багц 2-ын үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл 1,470,000.0 мянган төгрөг, "Шинэ хөдөө" төслийн багийн үйлдвэрийн тоног төхөөрөмж 546,956.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг бараа материалын тайланд бүртгэж, иргэдэд гэрээгээр олгосон байна. Мөн тусгай зориулалтын материал данснаас 26,309.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 453,666.6 мянган төгрөг болж 123,494.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд экспортыг дэмжих төслөөс 193,902.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хүлээн авч хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,739,720.0 мянган төгрөг болж 1,979,749.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд 476,369.8 мянган төгрөг, бусад төсөл хөтөлбөрт 1,233,200.0 мянган нийт зарлагыг 1,709.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 42,440.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс 518,810.0 мянган төгрөг баталсан байна. Төсөл хөтөлбөрийн зардлыг батлаагүй байна. Тайлант онд улсын төсвөөс баталсан хуваарийг 1 удаа өөрчилж төсвийг 130,036.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Энэ нь Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоол хэрэгжсэнтэй холбоотой цалингийн санг тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлж 648,046.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 325.232.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоор нийт 973,278.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 648,046.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвөөс орон нутгийн нэмэгдэл цалинд нийт 58,533.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 58,476.4 мянган төгрөгийг зарцуулж, 57.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 631,455.9 мянган төгрөг буюу 97.31 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2,487.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 738.9 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 2,429.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 4,735.2 мянган төгрөг, томилолт 1,066.5 мянган төгрөг, мэргэжлийн хяналтын зардлаас 1,950.0 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
УЛСЫН ТӨСӨВ					
1	70417 Мэргэжлийн хяналт	7,487.50	5,537.50	1,950.00	73.90%
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	7,487.50	5,537.50	1,950.00	73.90%
2	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	6,872.00	6,872.00	0	100.00%
2.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	5,600.00	5,600.00	0	100.00%
2.2	82542 Монгол мал хөтөлбөр	1,272.00	1,272.00	0	100.00%
3	70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	27,060.10	26,891.00	169.10	99.30%
3.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	27,060.20	26,891.00	169.10	99.30%
4	70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлага	607,426.80	592,155.46	15,271.34	97.48%
4.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	582,935.40	568,464.10	14,471.30	97.50%
4.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	24,491.40	23,691.36	800.04	96.73%
	Нийт дүн	648,846.4	631,455.96	17,390.44	97.31%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын захирамжийн хүрээнд нийт 266,698.7 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс олгож буй 40 хувийн нэмэгдэл цалин 58,533.4 мянган төгрөг нийт 325,232.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг байгууллагын зорилго, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулан аймгийн Засаг даргын захирамж, өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнаж, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд 2018-2024 онд хэрэгжиж буй монгол мал хөтөлбөр, хоршоог хөгжүүлэх, хүнсний ногоо, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх зэрэг 4 төсөл хөтөлбөр үргэлжлэн 2023 онд 100 хувь хэрэгжсэн байна. Төсөл хөтөлбөрүүдэд нийт 66,272.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Монгол мал хөтөлбөр	2023.12.31	Аймгийн хэмжээнд 848 толгой бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулснаар 83 толгой буюу 9,8% нь цөм сүрэг, 717 толгой 84,5% нь үржлийн сүрэг 48 толгой 5,7% нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдэж анги чанарыг тодорхойлон ажилласан.	100%	1.272,0	1.272,0
2	Хоршоог хөгжүүлэх	2023.12.31	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	15.000,0	15.000,0
3	Хүнсний ногоо	2023.12.31	Аймгийн хэмжээнд өрхийн тариалан эрхлэгч 500 өрхөд дэмжлэг үзүүлэх	100%	40.000,0	40.000,0
4	Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх	2023.12.31	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган ажиллах	100%	10.000,0	10.000,0

Тайлант онд Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилттэй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд агрономын тоног төхөөрөмж 1 багц буюу 13 нэр төрлийн 8,064.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шийдвэрээр хүлээн авч бараа материалын дансанд бүртгэсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардлаас 4,406.2 мянган төгрөгийн шатах тослох материал, нэмэлт данснаас 30,630.5 мянган төгрөгийн шатах тослох материалыг НИК ХХК-тай гэрээ байгуулж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 648,846.4 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 12,976.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахим дэлгүүрээс худалдан авалт хийх шаардлага гараагүй байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авсан судалгаагаар тус газар нь орлогч дарга, зөвлөх ажиллуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 талбарын мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны хуулийн мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 100 хувьтай үнэлэгдсэн тул зөрчилгүйд тооцов.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.

Завсрын аудитаар нийт 259.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 73.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан тул залруулагдсанд тооцов.

Завсрын аудитаар 180.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийн биелэлт хангагдаагүй тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулан тооцож 180.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймгийн Бэйкер Тилли Далайван Аудит ХХК гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 273.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 273.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн актыг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25-ний өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	273.6	1	273.6	100.0
Албан шаардлага	2	0	2	0	100.0
Зөвлөмж	2	0	2	0	100.0
Нийт дүн	5	273.6	5	273.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал төсвийн нэмэлт дансны санхүүжилт болох аймгийн Засаг даргын захирамжаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний зарцуулалтыг авч үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76,428.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 76,428.3 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 63,964.4 мянган төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд 640.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг биет хөрөнгө худалдан авсан зардалд тусгаагүй, бараа материалын дансанд 11,750.0 мянган төгрөгийн бараа материалыг дутуу илэрхийлснийг тус тус залруулав.
- Хоол унааны нэмэгдэл 73.9 мянган төгрөгийг томилолтын хугацаанд давхардуулан олгосныг аудитын явцад суутган тооцсон.
- Иргэдэд олгосон хүлэмжийг гэрээ хийж баталгаажуулсан.
- Дотоод хяналтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, тайлагнасан тул тус бүр залруулагдсанд тооцов.

Аудитаар нийт 3,355.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,092.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2,263.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын дарга өөрөө өөртөө тушаал гарган 180.0 мянган төгрөгийн нэг удаагийн шагнал урамшуулал авсан, байгууллагын 2023 оны аваргаар 1 албан хаагч шалгаруулж цалингийн зардлаас 912.0 мянган төгрөгөөр шагнасан зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын төсөвт тусгаагүй, төсвийн хэмнэлтээс ахмадын санд 900.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.3-т "төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын сан байгуулах хөрөнгийг тухайн жилийн төсөвтөө батлуулж байх.

2. Бараа материалын данстай холбоотой

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт:

Тайлант онд 1,363.9 мянган төгрөгийн хаалгыг шууд зардлаар бүртгэж зарлагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүртгэл хөтлөлтийг хуулийн дагуу аккрузл сууриар бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөг/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 63,964.4 мянган төгрөгөөр дутуу	1	63,964.4			1	63,964.4	1	63,964.4				
Мөнгөн гүйлгээний тайланд 640.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг биет хөрөнгө худалдан авсан зардалд тусгаагүй,	1	640.0	1	640.0			1	640.0				
Бараа материалын дансанд 11,750.0 мянган төгрөгийн бараа материалыг дутуу	1	11,750.0	1	11,750.0			1	11,750.0				
Хоол унааны нэмэгдэл 73.9 мянган төгрөгийг томилолтын хугацаанд давхардуулан олгосон	1	73.9			1	73.9	1	73.9				
	4	76,428.3	2	12,390.0	2	64,038.3	4	76,428.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөг/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Байгууллагын дарга өөрөө өөртөө тушаал гарган 180.0 мянган төгрөгийн нэг удаагийн шагнал урамшуулал авсан байна.	1	180.0	1	180.0								
Байгууллагын 2023 оны аваргаар 1 албан хаагч шалгаруулж цалингийн зардлаас 912.0 мянган төгрөгөөр шагнасан	1	912.0	1	912.0								
Байгууллагын төсөвт тусгаагүй, төсвийн хэмнэлтээс ахмадын санд 900.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.	1	900.0					1	900.0				

Тайлант онд 1,363.9 мянган төгрөгийн хаалгыг шууд зардлаар бүртгэж зарлагдсан байна.	1	1,363.9					1	1,363.9				
дүн	4	3,355.9	2	1,092.0			2	2,263.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зерчлийн товч утга	Нийт зерчил		/мянган төгрөг/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зерчил											
												-
												-



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 47/А/1440340

Эрдэнэт хот

ОРА-2024/101/НА-СТА-ТУБЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дарга өөрөө өөртөө тушаал гарган 180.0 мянган төгрөгийн нэг удаагийн шагнал урамшуулал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь байгууллагын дарга өөрөө өөртөө тушаал гарган авсан шагнал 180,000 (Нэг зуун наян мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Бат-Өлзий), нягтлан бодогч (О.Буянхишиг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 36/АМНТДЗЧО
ОРА-2024/10/НА-СТА-ТУК

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2023 оны аваргаар 1 албан хаагч шалгаруулж цалингийн зардлаас 912,000 төгрөгөөр шагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь цалингийн зардлаас шагнасан 912,000 (Есөн зуун арван хоёр мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

- 2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Бат-Өлзий), нягтлан бодогч (О.Буянхишиг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812